



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠭᠭᠠᠨ ᠰᠤᠲᠤ ᠬᠡᠭᠢ  
ᠰᠤᠭᠭᠠᠨ ᠰᠤᠲᠤ ᠬᠡᠭᠢ

ЖИЛИЙН ТАЙЛАН-2012



## АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4
Компанийн бүтэц, зохион байгуулалт	5-6
Стратеги хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ”-ний хэрэгжилтийн явц	7-8
2012 оны онцлох үйл явдлууд	9-10
Үнэт цаасны бүртгэл	11
Үнэт цаасны арилжаа	12-16
ТОП-20 Индекс	17
Гишүүн компаниудын жагсаалт	18-19
МХБ-ийн санхүүгийн үзүүлэлт	20-21



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Монголын хөрөнгийн биржийн эрхэм зорилго нь санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгээр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэг бүхий үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино.

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



### Эрхэм хүндэт уншигчид аа,

Та бүхэнд Монголын хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 22 жилийн ойн мэндийг хүргэж мэндчилье.

Улирагч 2012 он Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд түүхэн шинэчлэл хийгдсэн, ажлын үр бүтээлээр арвин жил болж өнгөрлөө. 2012 онд нийт 145.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 133.8 сая ширхэг үнэт цаасны арилжаа явагдсан бөгөөд арилжааны хэмжээ өмнөх онохоос 32.6 хувиар өслөө. Хөрөнгө оруулагчдад очих хувьцааны өгөөж буюу ногдол ашиг 79.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 4.8 тэрбум төгрөгөөр өсч, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үйл ажиллагаа улам идэвхжиж байна.

Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн бирж групп болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хооронд байгуулагдсан стратеги хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ”-ний дагуу Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хяналт, хадгаламжийн цогц шийдэл бүхий “Миллениум АйТи” системийг 2012оны 7 дугаар сараас амжилттай нэвтрүүлэн ашиглаж байна. Түүнчлэн, эрх зүйн орчны шинэчлэл, төлбөр тооцооны Т+3 системийг нутагшуулах, хөрөнгийн зах зээлд оролцогчдыг сургах ажлуудыг гүйцэтгэж тодорхой үр дүнд хүрч чадлаа.


Мөн олон улсын хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгаагаар тэргүүлэгч “ФУТСИ групп” /FTSE/ компани Монгол Улсыг хөгжиж буй орны жагсаалтынхаа ажиглалтын жагсаалтад оруулсан зэрэг олон амжилтаар дүүрэн 22 жилийнхээ ойг угтаж байна.

Хөрөнгийн зах зээлийн хөгжил шинэчлэлийн төлөө бид бүхэнтэй хамтран ажиллаж буй нийт харилцагч, хөрөнгө оруулагчид, мэргэжлийн байгууллагууд, үнэт цаас гаргагчид та бүхэндээ Монголын хөрөнгийн биржийн нэрийн өмнөөс сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ирж буй 2013 онд манай улсын хөрөнгийн зах зээл амжилт бүтээлээр дүүрэн байна гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,  
Х.АЛТАЙ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

## КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- М.БАТГЭРЭЛ, ТУЗ-ийн дарга
- Б.ДААЖАМБА, ТУЗ-ийн гишүүн
- Г.БАТХҮРЭЛ, ТУЗ-ийн гишүүн
- Б.БАЯР, ТУЗ-ийн гишүүн
- А.ХҮРЭЛБАТ, ТУЗ-ийн гишүүн
- М.БАЯНМӨНХ, ТУЗ-ийн гишүүн
- Д.БОЛОРМАА, ТУЗ-хараат бус гишүүн
- Ч.ГАНБАТ, ТУЗ-ийн хараат бус гишүүн
- Ж.МАЙЗОРИГ, ТУЗ-ийн хараат бус гишүүн

### ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- Х.АЛТАЙ, Гүйцэтгэх захирал
- Г.САРУУЛ, Бодлого зохицуулалт хариуцсан дэд захирал
- Э.БАТБАЯР, Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал

## АЛБАДУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Мэдээллийн технологийн алба** - үндсэн үйл ажиллагааны програм бичих, нэмэлт хийх, програм хангамжийн найдвартай байдлыг хангуулах, дотоод сүлжээ, ажлын үндсэн сервер, техник, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангуулах, засвар үйлчилгээг хариуцаж ажилладаг.

**Арилжааны алба** - үнэт цаасны арилжааны бэлэн байдлыг хангах, арилжааг удирдан зохион байгуулах, арилжааны явцыг хянах, арилжааны болон зах зээлийн холбогдолтой мэдээ, мэдээллийг боловсруулах, олон нийтэд арилжааны мэдээллийг түгээх.

**Мэдээллийн алба** - олон нийтэд хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээлэл, сурталчилгаа явуулах, хэвлэл, мэдээллийн мэргэжлийн байгууллагатай нягт хамтран ажиллах, хэвлэл гаргах, хэвлэлийн хурал, мэдээллийн өдөрлөг, ажлын уулзалт, ярилцлага, семинар зохион байгуулах, МХБ-ийн цахим хуудсаар хөрөнгийн зах зээлийн талаар боловсрол, мэдээлэл түгээх зэрэг чиглэлээр ажилладаг.

**Хяналтын алба** - албаны үндсэн зорилго үнэт цаасны арилжааг шударга, ил тод явуулах, хөрөнгө оруулагчдын нийтлэг эрх ашгийг хамгаалахад оршино. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны дүрэм журмууд болон МХБ-ийн Хяналтын журмын хүрээнд МХБ-д бүртгэлтэй ХК, үнэт цаасны арилжаа, гишүүн компанийн үйл ажиллагаа зэрэгт хяналт тавих чиглэлээр хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулдаг.

**Гишүүн зохицуулалтын алба** - Монголын хөрөнгийн биржид шинээр гишүүн элсүүлэх, гишүүн компаниудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, үүргийн биелэлтийг хангуулах, арилжаанд оролцогчдыг аттестатчилах, үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох, гишүүн компаниудтай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

**Бүртгэлийн алба** - үнэт цаас бүртгэн авах, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, бүртгэлийн шаардлага, шалгуур, ангиллыг тогтоож мөрдүүлэх, бүртгэлтэй компаниудын хууль тогтоомж, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулах, компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч ажилладаг.

**Анхдагч зах зээлийн алба** - Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө босгох эрмэлзэлтэй дотоод, гадаадын хуулийн этгээдүүдийн үнэт цаасыг олон нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд өөрийн эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгч хөрөнгийн зах зээлд үнэт цаас гарахад дэмжиж ажиллах, чанартай бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх чиг үүрэг бүхий алба юм.

**Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн төв** - хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх ажлуудыг үр дүнтэй зохион байгуулахад туслалцаа үзүүлэх, хөрөнгийн зах зээлийн амжилтаас үйл ажиллагаа нь хамаарч байдаг хуулийн этгээдүүдийг холбож, олон талт хамтын ажиллагааг бий болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

**Санхүүгийн алба** - компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааг сайжруулах, үнэт цаасны арилжааны шимтгэлийн тооцоог хийх, байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр ажилладаг.

**Хүний нөөцийн алба** - байгууллагын дотоод зохион байгуулалт, хүний нөөцийн бүрдүүлэлт, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, санхүү, хөрөнгийн зах зээлийн олон талт мэдлэг, мэргэшил бүхий боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх, эрчимтэй, бүтээлч байдлыг бий болгох чиг үүрэгтэй.

## СТРАТЕГИ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ “АЖЛЫН МАСТЕР ГЭРЭЭ”-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газраас 2010 оны 115 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай” бодлогын баримт бичгүүдэд үндэслэн, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, дотоодын эдийн засгийн асар хурдацтай өсөлтийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан дэмжих, эрчимжүүлэх зорилгыг Монгол Улсын Засгийн газраас тавьсан билээ.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхээр Төрийн өмчийн хороо /ТӨХ/, Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп /ЛХБГ/ нь 2010 оны 12-р сарын 24-ний өдөр “Стратегийн түншлэлийн хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурж, Монголын Хөрөнгийн Бирж /МХБ/, ТӨХ, ЛХБГ хамтран 2011 оны 4-р сарын 7-ны өдөр зах зээлийг хөгжүүлэх “Ажлын мастер гэрээ”-г байгуулан, шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн билээ. Энэхүү гэрээний хүрээнд 2012 онд дараах ажлууд хийгдлээ:



4 сарын 7, 2011

Ажлын мастер гэрээнд гарын үсэг зурах ёслол

### Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох /Хууль, дүрэм, журмын шинэчлэл/:

Монголын хөрөнгийн бирж нь өөрийн үндсэн үйл ажиллагаанд мөрдөгддөг “Электрон арилжааны системийн арилжаа журам” болон “Гишүүнчлэлийн журам”-г шинэ системд нийцүүлэн шинэчлэн баталсан бөгөөд Бүртгэлийн, Гишүүнчлэлийн болон бусад холбогдох журмуудад шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулан батлуулсан юм. Түүнчлэн, Лондонгийн хөрөнгийн бирж болон Монголын хөрөнгийн биржийн баг бүрэлдэхүүн хамтран “Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төслийг боловсруулах ажлын хүрээнд судалгаа шинжилжээ хийж холбогдох саналуудыг хүргүүлсэн болно.

### Техник технологийн шинэчлэл:

Ажлын мастер гэрээнд тусгагдсаны дагуу ЛХБГ-ийн охин компани болох "Миллениум АйТи" Софтвэйр Лимитэд компаний үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламж, хяналтын цогц системийг дотоодын зах зээлд цогцлоон суурилуулж, бүрэн ашиглалтад оруулснаар 2012 оны 7-р сарын 2-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн зах зээлийн арилжаа, хяналт, төлбөр тооцоо ба үнэт цаасны хадгаламж Миллениум АйТи арилжааны цогц системээр явагдах болсон.

Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын цогц шийдэл бүхий “Миллениум Ай Ти” системийг суурилуулсантай холбоотойгоор үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо нь урьдчилсан төлбөрт системээр буюу үнэт цаас худалдан авагч нь арилжааны төлбөрийг захиалга өгөхөөс өмнө урьдчилан байршуулсны үндсэнд арилжаанд оролцох байдлаар явагддаг байсныг дараа төлбөрт Т+3 системд шилжүүлсэн. Ийнхүү төлбөр тооцооны шинэ системд шилжсэнээр үнэт цаасны төлбөр тооцоо арилжаа хийгдсэнээс хойш 3 дахь өдөрт хийгдэх болсон ба мөнгөн төлбөр Төлбөр тооцооны банкуудаар хийгдэх болсноор хөрөнгө оруулагчдад төлбөрийн уян нөхцөл бүрдсэнээс гадна өөрийн мөнгөн хөрөнгөнд хүү тооцуулан хадгалах боломжтой болсон билээ.



12 сарын 17, 2012

Миллениум Ай Ти системийн хүлээн авах ёслолын арга хэмжээ

Миллениум Ай Ти системийг суурилуулсантай холбоотойгоор үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо нь урьдчилсан төлбөрт системээр буюу үнэт цаас худалдан авагч нь арилжааны төлбөрийг захиалга өгөхөөс өмнө урьдчилан байршуулсны үндсэнд арилжаанд оролцох байдлаар явагддаг байсныг дараа төлбөрт Т+3 системд шилжүүлсэн. Ийнхүү төлбөр тооцооны шинэ системд шилжсэнээр үнэт цаасны төлбөр тооцоо арилжаа хийгдсэнээс хойш 3 дахь өдөрт хийгдэх болсон ба мөнгөн төлбөр Төлбөр тооцооны банкуудаар хийгдэх болсноор хөрөнгө оруулагчдад төлбөрийн уян нөхцөл бүрдсэнээс гадна өөрийн мөнгөн хөрөнгөнд хүү тооцуулан хадгалах боломжтой болсон билээ.





2011 оны 9-р сар

Сургалт, Лондон хот

### Зах зээлийг хөгжүүлэх, сурталчилах чиглэлээр:

2012 онд МХБ нь дотоодын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгө оруулагчдад сурталчлан таниулахаар түлхүү анхаарч ажилласан ба энэхүү зорилтын хүрээнд Улаанбаатар хотод "IPO Mongolia 2012" чуулганыг бие даан, санаачлан зохион байгуулж олон улсын хөрөнгө оруулагчдад өөрийн орны онцлог, давуу талыг танилцуулахаас гадна дотоодын аж ахуйн нэгжүүдийг олон улсын хөрөнгө оруулагчидтай үүлзүүлж цаашдын хамтын ажиллагааны үл сүүрийг тавьсан билээ. Түүнчлэн, Лондонгийн хөрөнгийн бирж групптэй хамтран "Монголын хөрөнгийн зах зээлийн өдөрлөг", "Монгол, Британийн бизнесийн чуулган"-ыг Лондон хотод, БНХАУ-ын тусгай захиргааны бүс Хонг Конг дахь Монгол Улсын Элчид сайдын яамтай хамтран "Эдийн засгийн хэлэлцүүлэг: Монголд Хөрөнгө оруулах нь" сэдэвт дугуй ширээний үулзалтыг Хонг Конгд тус тус амжилттай зохион байгуулж илтгэл тавин оролцсон юм. Шанхай хотноо зохион байгуулагдсан "Азийн цэвэр нүүрсний дээд хэмжээний үулзалт", Улаанбаатар хотод зохиогдсон "Монголын эдийн засгийн чуулган 2012" гэх мэт бусад олон улсын чанартай хөрөнгө оруулалт, эдийн засгийн чуулга үулзалтуудад тогтмол илтгэл тавин Монголын хөрөнгийн биржийн сурталчилгааны булан ажиллуулан оролцож байсан нь зах зээлийн идэвхжүүлэхэд түлхэц болсон гэж дүгнэж байна.

### Хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах чиглэлээр:

"Миллениум Ай Ти" компанийн систем угсралтын мэргэжилтнүүд Улаанбаатарт ирж ажилласан бөгөөд ажиллах хугацаандаа дотоодын брокерууд, Монголбанк, СЗХ, МХБ болон ҮЦТТХТ-ийн ажилтнуудыг шинэ системд мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион явуулсан.

Дотоодын Хөрөнгийн зах зээлийн индекс тооцооллыг боловсронгуй болгож, олон улсын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын зах зээлүүдийн индекс тооцоолол мөн зэрэглэл тогтоогч FTSE Групптэй холбоо тогтоон хамтын ажиллагааны талаар хэлэлцэж эхлээд байна.

Монголын хөрөнгийн бирж, хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй мөн ойлгомжтой болгох зорилгоор өөрийн цахим хуудсыг бүрэн шинэчилж хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголтуудын талаар хичээл, гарын авлагуудыг вэб хуудсаараа дамжуулан бэлтгэн хүргэж байгаагаас гадна ард иргэдийн дунд анхан шатны мэдлэг олгох сургалтыг долоон удаа зохион байгуулж 200 гаруй ирээдүйн хөрөнгө оруулагч, салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэн, чиглүүлсэн юм.



Монголын хөрөнгийн биржийн мэдээллийн алба нь 2012 оны 8-р сараас эхлэн зах зээлийг сонирхогч ард иргэд, байгууллагуудын цахим шуудангийн хаягийг өөрийн вэб хуудсанд бүртгэн авч улмаар 2 долоо хоног тутамд зах зээл дээр болж өнгөрсөн үйл явдлын албан ёсны дэлгэрэнгүй мэдээллүүдийг багцлан электрон сонин хэлбэрээр үнэ төлбөргүй илгээх болсноор оны эцэст нийт 1 000 гаруй захиалагчидтай болоод байна.



## 2012 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Монголын хөрөнгийн зах зээлийн өдөрлөг /Лондон хот-2012-04-30/

### **“IPO workshop” Хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах нь-02/28/2012**

Монголын олон улсын хөрөнгийн корпораци /МИСС/-тай хамтран дотоодын зах зээлд үнэт цаас гаргах боломжтой томоохон компаниудад зориулан “IPO workshop” буюу нээлттэй өдөрлөг, уулзалтыг амжилттай зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгт дотоодын 50 гаруй томоохон компанийн удирдлагуудыг оролцуулан дотоодын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа хэрхэн гаргаж болох талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

### **“IPO Mongolia-2012” Чуулга уулзалт-03/07/2012**

Монгол Улсын Ерөнхий Сайдын ивээл дор Монголын Хөрөнгийн Бирж, Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп болон ИБУИНВУ дахь Монгол Улсын ЭСЯ хамтран “IPO Mongolia-2012” чуулга уулзалтыг зохион байгуулсан. Уг чуулга уулзалт нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн асуудалд олон улсын анхаарлыг хандуулаад зогсохгүй Монголын компаниудыг гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгоход нь дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Тус чуулга уулзалтад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, түүнчлэн Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгж, хувьцаат компаниудын удирдах албаны 300 гаруй төлөөлөгчид оролцсон юм.

### **“Монголын хөрөнгийн зах зээл өдөрлөг” Лондонд Монголын компаниудыг таниулах арга хэмжээ-04/30/2012**

“Монголын хөрөнгийн зах зээлийн өдөрлөг” -ийг Лондон хотноо 2012 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд Монгол улсын хувийн хэвшлийн салбарын тэргүүлэх компаниудын болон олон улсын хөрөнгө оруулагчдын төлөөллийг хамарсан 250 гаруй зочид, төлөөлөгчид оролцсон. Энэ үеэр хөрөнгө оруулагчдад Монголын хөрөнгийн зах зээлийг сурталчлах, Монгол компаниуд болон олон улсын хөрөнгө оруулагчдыг хооронд нь зуучлан танилцуулах чухал ач холбогдол бүхий арга хэмжээ болов.

## 2012 HIGHLIGHTS



*/Зүүнээс: СЗХ-ны Дэд дарга Б.Даажамба, ЛХБГ-ын Стратеги хариуцсан захирал Дэвид Лэстер, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, МХБ-ийн ТУЗ-ийн дарга М.Батгэрэл, Улаанбаатар хот, 2012-12-17/*

### **“Миллениум Ай Ти” шинэ систем нэвтэрлээ-07/02/2012**

Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн бирж групп болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хооронд байгуулагдсан стратеги хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ”-ний дагуу хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт хүргэх, дэд бүтцийг сайжруулах зорилтын хүрээнд үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хяналт, хадгаламжийн цогц шийдэл бүхий “Миллениум Ай Ти” системийг Монголын хөрөнгийн зах зээлд амжилттай нэвтрүүлэв.

### **“Монгол-Британийн бизнесийн чуулга уулзалт”-07/30/2012**

Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа Элчин сайдын яам болон Монгол Британий худалдааны танхимтай

хамтран хоёр талын худалдаа, эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэх чиглэлээр “Монгол-Британийн бизнесийн чуулга уулзалт-2012” чуулга уулзалтыг зохион байгууллаа. Кентийн хунтайж Майкл, Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж болон Лондонгийн хөрөнгийн бирж группын гүйцэтгэх захирал Завиэр Ролэ нар энэхүү чуулга уулзалтад оролцож үг хэлсэн байна.

**09/25/2012** - Олон улсын хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгаагаар тэргүүлэгч FTSE группээс Монгол Улсыг “Хөгжиж буй зах зээл”-ийн жагсаалтын ажиглалтын жагсаалтад оруулсан тухай албан ёсоор мэдэгдэв.

### **“Миллениум Ай Ти” системийн албан ёсоор хүлээн авах ёслолын арга хэмжээ-12/17/2012**

“Миллениум Ай Ти” системийг хүлээн авах ёслолын арга хэмжээ 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдөр болов. Ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, ЛХБГ-ын Стратеги хариуцсан захирал Дэвид Лэстер, СЗХ-ны Дэд дарга Б.Даажамба, МХБ-ийн ТУЗ-ийн дарга М.Батгэрэл, Гүйцэтгэх захирал Х.Алтай нар системийг хүлээн авах ёслолын туузыг хайчилсан. Тус арга хэмжээнд МХБ-ийн ТУЗ-ийн гишүүд, холбогдох дээд байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, ЛХБ-ийн удирдах албан тушаалтнууд, “Миллениум Ай Ти” компаний баг бүрэлдэхүүн, брокер, дилерийн компаниудын төлөөлөл болон бусад холбогдох албан тушаалтнууд оролцсон.

## ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

2012 оны 12-р сарын 31-ний байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 329 ХК байгаагаас 23 ХК буюу 6.9% нь 100 хувь төрийн өмчит, 29 ХК буюу 8.8% нь төрийн өмчийн оролцоотой, 277 буюу 84.2% ХК нь бүрэн хувьчлагдсан буюу олон нийтэд нээлттэй компани байна.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт 4.78 тэрбум ширхэг хувьцаа байгаагаас 2.08 тэрбум ширхэг буюу 43.7% нь төрийн мэдлийн, 2.69 тэрбум ширхэг буюу 56.3% нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.

**2012 онд шинээр бүртгэгдэж хувьцаагаа олон нийтэд санал болгосон компани:**

№ Компанийн нэрс	Тоо ширхэг	Бүртгэгдсэн огноо
1 "Э-Транс логистикс" ХК	46,200,000	2012.04.20

**2012 онд МХБ-д шинээр бүртгэгдсэн компани:**

№ Компанийн нэрс	Тоо ширхэг	Бүртгэгдсэн огноо
1 "Бэрэн майнинг" ХК	1,740,813,320	2012.12.19

**2012 онд нэмж хувьцаа гаргасан компаниуд:**

№ Компанийн нэрс	Тоо ширхэг
1 "Монголын төмөр зам" ХК	207.05 сая
2 "Эрдэнэт суврага" ХК	120.4 сая
3 "Азиапасифик пропертис" ХК	177.5 сая

Тайлангийн хугацаанд "Баянгол ЗБ" ХК, "Тахь-ко" ХК, "Атар өргөө" ХК-иудын хувьцааны нэрлэсэн үнэ өөрчлөх, "Өвөрхангай ханын материал" ХК-ийн оноосон нэрийг "Глобал монголиа холдинг" ХК болгон солих шалгалт хийж, үнэт цаасны бүртгэлд зохих өөрчлөлтүүдийг оруулсан.

**2012 онд бүртгэлээс хасагдсан компаниуд:**

- "Монэнзим" ХК
- "Батширээт" ХК,
- "Дэлгэрхүнс" ХК,
- "Хурх гол" ХК,
- "Байгууламж" ХК.

Үзүүлэлт	2011	2012	Өөрчлөлт
МХБ-д бүртгэлтэй компаниуд	332	329	-3
-Төрийн өмчит	52	52	-
-Хувийн өмчит	280	277	-3
Бүртгэгдсэн үнэт цаасны тоо	2,785,465,029	4,779,295,577	1,993,830,548
-Төрийн өмчит	1,881,180,046	2,088,231,046	207,051,000
-Хувийн өмчит	904,284,983	2,691,064,531	1,786,779,548
Үнэт цаас шинээр бүртгүүлсэн ХК	1	2	1
-Төрийн өмчит ХК	1	-	-1
-Хувийн өмчийн	-	2	2
Шинээр бүртгүүлсэн үнэт цаасны тоо /ш/	226,000	1,787,013,320	1,786,787,320
Нэмж бүртгүүлсэн үнэт цаасны тоо /ш/	19,222,300	207,348,968	188,126,668
Бүртгэлээс хасагдсан ХК	5	5	-
Хасагдсан үнэт цаасны тоо /ш/	1,053,637	531,740	-521,897
Хувь нийлүүлэгчдийн хурал зарласан ХК	155	209	54
Ноогдол ашиг тараасан ХК-иуд	28	29	1
Тайлан балансаа илгээсэн ХК-иуд	158	180	22

Бүртгэлийн алба:

Утас: (+976)-11-310517 /119, 120, 134, 142/

Факс: (+976)-11-325170

И-мэйл: listing@mse.mn




## ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 250 удаагийн арилжаагаар 149 компанийн 133.7 сая ширхэг хувьцааг 144.7 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын энгийн 5 ширхэг бондыг 525.0 мянган төгрөгөөр, 30.9 мянган ширхэг компанийн бондыг 309.7 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 145.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 133.8 сая ширхэг үнэт цаас арилжсан байна.


Нийт арилжааны хэмжээг өмнөх онтой харьцуулбал хувьцааны арилжааны үнийн дүн 35.6 тэрбум төгрөгөөр буюу 32.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд хувьцааны арилжааны өдрийн дундаж үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 33.7 хувиар өсч, өдөрт дунджаар 579.0 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Үзүүлэлт	2011	2012
Арилжаа явагдсан өдөр	252	250
Үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо	148	149
Зах зээлийн нийт үнэлгээ /төгрөг/	2,168,569,984,199.00	1,799,898,913,892.00
/ам доллар/	1,553,005,281.00	1,292,937,945.47
Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	350,235,908,611 .00	145,056,711,537.00
Хувьцаа	109,110,768,611.00	144,746,456,537.00
Засгийн газрын бонд	236,730,600,000.00	525,000.00
Компанийн бонд	4,394,540,000.00	309,730,000.00
Нийт арилжигдсан үнэт цаасны тоо /ширхэг/	125,590,669	133,829,203
Хувьцаа	122,783,909	133,798,200
Засгийн газрын бонд	2,367,306	5
Компанийн бонд	439,454	30,973
Нийт хийгдсэн хэлцлийн тоо	48,206	26,998
Өдрийн дундаж /хувьцааны арилжаагаар/		
Үнийн дүн /төгрөг/	432,979,241	578,985,826.00
Үнийн дүн /ам.доллар/	310,075	415,908.21
Арилжигдсан ширхэг	487,238	535,193
Хэлцлийн тоо	191	108
Төгрөг ам. доллартай харьцах ханш /жилийн эцсийн Монгол банкны ханш/	1,396.37	1,392.10



## Статистик



**ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 20 ҮНЭТ ЦААС**

Үнэт цаас	Хаалтын ханш /төгрөгөөр/		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
	2011.12.30	2012.12.31		
ӨНДӨРХААН	180	6,600.00	6420.00	3566.67
ЦАГААН ТОЛГОЙ	213	7,800.00	7587.00	3561.97
МОНАСАР	419	11,050.00	10631.00	2537.23
ЦАГДУУЛТАЙ	115	1,175.00	1060.00	921.74
НОЁТ ХАЙРХАН	264	2,640.00	2376.00	900.00
ХАР ТАРВАГАТАЙ	1,146	9,305.00	8159.00	711.95
ХӨДӨӨ ТЭЭВЭР	173	1,380.00	1207.00	697.69
СОЛОНГО ЭКСПРЕСС	575	4,200.00	3625.00	630.43
СЭЛЭНГЭ СҮРЭГ	253	1,700.00	1447.00	571.94
МОНГОЛЫН ГЭГЭЭ	285	1,530.00	1245.00	436.84
ХАРГИА	1,150	5,300.00	4150.00	360.87
АЛТАЙН ЗАМ	115	456.56	341.56	297.01
МОНГОЛ ШИР	330	1,300.00	970.00	293.94
ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	400	1,502.00	1102.00	275.50
ЭРДЭНЭТ СУВРАГА	2,082	7,670.00	5588.00	268.40
БАЯН АЛДАР	733	2,400.00	1667.00	227.42
ЭРЭЭНЦАВ	500	1,530.00	1030.00	206.00
МОНГОЛ АЛТ	2,116	6,460.00	4344.00	205.29
ЖИНСТ УВС	150	450.00	300.00	200.00
ХАНЫН МАТЕРИАЛ	609	1,815.00	1206.00	198.03

**ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 20 ҮНЭТ ЦААС**

Үнэт цаас	Хаалтын ханш /төгрөгөөр/		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
	2011.12.30	2012.12.31		
ХЭРЭГЛЭЭ ИМПЕКС	12,928	3,870.00	-9058.00	-70.06
АДУУНЧУЛУУН	6,000	1,803.00	-4197.00	-69.95
УБ БҮК	32,500	11,900.00	-20600.00	-63.38
ХИШИГ УУЛ	2,150	850.00	-1300.00	-60.47
БАГАНУУР	13,100	5,280.00	-7820.00	-59.69
МОГОЙН ГОЛ	31,000	13,000.00	-18000.00	-58.06
МОНГОЛ САВХИ	2,587	1,250.00	-1337.00	-51.68
ТӨМРИЙН ЗАВОД	50,000	27,600.00	-22400.00	-44.80
СОР	3,820	2,200.00	-1620.00	-42.41
ИХ БАРИЛГА	8,750	5,200.00	-3550.00	-40.57
ОЛЛОО	239	145.00	-94.00	-39.33
БАЯЛАГ НАЛАЙХ	1,200	780.00	-420.00	-35.00
ШИВЭЭ ОВОО	15,300	10,000.00	-5300.00	-34.64
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	580	380.00	-200.00	-34.48
МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	2,700	1,850.00	-850.00	-31.48
БИШРЭЛТ ИНДАСТРИЛ	2,000	1,395.00	-605.00	-30.25
САВ ШИМ	1,955	1,400.00	-555.00	-28.39
АЛМААС	2,512	1,800.00	-712.00	-28.34
ХАСУ МАНДАЛ	1,840	1,350.00	-490.00	-26.63
БАЯНТЭЭГ	36,000	26,450.00	-9550.00	-26.53



## 2012 онд идэвхтэй арилжигдсан үнэт цаас

Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Эрэмбэ	Үнэт цаас	Үнийн дүн /төгрөгөөр/
ЖЕНКО ТУР БЮРО	30,609,795	1	ШАРЫН ГОЛ	54,338,667,777
ХӨХ ГАН	19,468,032	2	БЭРХ УУЛ	26,918,187,362
Э- ТРАНС ЛОЖИСТИКС	11,841,609	3	ШИВЭЭ ОВОО	9,701,740,180
БЭРХ УУЛ	10,759,950	4	БАГАНУУР	9,160,662,588
НАКО ТҮЛШ	8,886,669	5	БИДИСЕК МОНГОЛИА	8,107,868,248
РЕМИКОН	7,742,459	6	ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС	3,988,710,805
ГЕРМЕС ЦЕНТР	6,085,292	7	ХӨХ ГАН	3,680,891,350
ШАРЫН ГОЛ	5,959,564	8	МОНГОЛ ШИЛТГЭЭН	3,111,988,815
МОНИНЖБАР	5,721,102	9	ЖЕНКО ТУР БЮРО	2,818,326,679
МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС	4,107,627	10	АПУ	2,428,080,865

Тайлант хугацаанд 150 компанийн үнэт цаас арилжигдсанаас 102 компанийн үнэт цаасны ханш өсч, 45 компанийн үнэт цаасны ханш буурч, 3 компанийн үнэт цаасны ханш тогтмол байсан.

### **Засгийн газрын бондын арилжаа**

2012 онд Засгийн газрын бондын арилжаа 1 удаа явагдаж, бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 366 хоногийн хугацаатай, жилийн 7.5 хувийн хүүтэй, нэг бүрийн нэрлэсэн үнэ нь 100,000 төгрөгийн үнэтэй 5 ширхэг бондыг нийт 525,000 төгрөгөөр арилжлаа.

### **Компанийн бондын арилжаа**

Компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаагаар “Жаст агро” компанийн нэг бүр нь 10.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 500 ширхэг “Монгол мах” бондыг 5.0 сая төгрөгөөр, мөн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 30.5 мянган ширхэг бондыг 304.7 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 309.7 сая төгрөгийн арилжаа хийсэн байна.

### **Багцын арилжаа**

2012 онд нийт 46 удаагийн багцын арилжаагаар 19 үнэт цаасны 87.2 сая ширхэг хувьцааг 123.0 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 85.0%-ийг эзэлж байна.

### **Анхдагч зах зээлийн арилжаа**

2012 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн анхдагч зах зээлийн арилжаагаар тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Э-Транс Ложистикс” ХК нь 7.7 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон захиалгын бүртгэлийн аргаар анхдагч зах зээлд байршуулан 924.0 сая төгрөгөөр арилжлаа.

### **Зах зээлийн үнэлгээ**


Зах зээлийн нийт үнэлгээг өмнөх онтой харьцуулахад 368.7 тэрбум төгрөгөөр буюу 17.00 хувиар буурч, 1 их наяд 799.9 тэрбум төгрөг болсон байна.

## ХАМГИЙН ӨНДӨР ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ 30 КОМПАНИ

Үнэт цаасны нэр	Үйл ажиллагааны чиглэл	Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөгөөр/
ТАВАН ТОЛГОЙ /TTL/	Нүүрс олборлолт, борлуулалт	463.5
АПУ /APU/	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	283.3
ШИВЭЭ ОВОО /SHV/	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	134.2
БЭРХ УУЛ /BEU/	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	120.1
БАГАНУУР /BAN/	Нүүрс олборлолт	110.7
ШАРЫН ГОЛ /SHG/	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	90.0
МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО /MCH/	Цахилгаан холбоо	47.9
БИДИСЕК /BDS/	Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх	39.9
ГОВЬ /GOV/	Нэхмэлийн үйлдвэрлэл	35.1
МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС /MSC/	Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх	30.0
СҮҮ /SUU/	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	27.5
УЛААНБААТАР ЗБ /ULN/	Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх	27.5
ХӨХ ГАН /HGN/	Төмрийн баяжмал үйлдвэрлэл	17.2
БАЯНГОЛ ЗБ /BNG/	Зочид буудал	15.9
РЕМИКОН /RMC/	Барилгын материалын үйлдвэр	14.9
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР /UID/	Худалдаа үйлчилгээ	14.0
МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС /MDR/	Үл хөдлөх хөрөнгө, түрээс	13.7
УБ БҮК /BUK/	Барилгын материал үйлдвэрлэл	13.4
ТАЛХ ЧИХЭР /TCK/	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	12.6
АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС /APP/	ХАА-н бүтээгдэхүүн	11.6
МОГОЙН ГОЛ /BDL/	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	10.8
МОНГОЛ ШИЛТГЭЭН /MSH/	Ресторан, Зочид буудал, аялал жуулчлал	10.0
ЭЭРМЭЛ /EER/	Ноос боловсруулах	9.7
МОНГОЛ ЭМИМПЕКС /MEI/	Эмийн худалдаа, хангамж	9.6
СИЛИКАТ /SIL/	Шохойн үйлдвэр	9.2
ЖЕНКО ТУР БЮРО /JTB/	Зочид буудал, аялал жуулчлал	9.0
ГЕРМЕС ЦЕНТР /HRM/	Түрээс, лизингийн үйл ажиллагаа	7.9
ГУТАЛ /GTL/	Үл хөдлөх хөрөнгийн түрээс	7.6
АТАР ӨРГӨӨ /ATR/	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7.3
ТАХЬ КО /TAN/	Үл хөдлөх хөрөнгийн түрээс	7.1
Нийт зэх зээлийн үнэлгээ		1,611.3
Нийт зах зээлд эзлэх хувь		89.5

Зах зээлийн үнэлгээгээрээ тэргүүлэгч 30 компани нь нийт зах зээлийн 89,5 хувийг эзэлж байна.

## ТОП-20 ИНДЕКС



Дээд: **21,747.64**

Дундаж: **19,049.77**

Доод: **15,101.91**

ТОП-20 индексийн бүүралтад индексийн сагсанд багтдаг Багануур /59.69%, Могойн гол /58.06%, Шивээ Овоо /34.64%, Улсын Их Дэлгүүр /34.48%, Монголын цахилгаан холбоо /31.48%, Шарын гол /22.51%, Таван толгой /20.00%, Хөх ган /15.00%, Говь /12.64%,

Силикат /11.56%, АПУ /9.21%, Женко түр бюро /4.26%, Монголиа ресорс девелопмент /1.09% зэрэг ХК-иудын үнэт цаасны ханш бүүрсан нь нөлөөлжээ.

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГИШҮҮН КОМПАНИУД

2012 оны эхэнд нийт 76 гишүүн компани үйл ажиллагаа эрхэлж байсан ба тайлант хугацаанд **“Голомт секьюритиз” ХХК, “Сикап” ХХК, “Прогресс партнерс” ХХК, “Түшиг траст” ХХК** гишүүнээр элсэж, 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 80 гишүүн компанид 578 ажилтан бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Үзүүлэлт	2011.12.31	2012.12.31	Өөрчлөлт
Гишүүн компанийн тоо	76	80	4
Брокер, дилер /БД/	46	47	1
БД, андеррайтер	18	17	(1)
БД, зөвлөх	8	9	1
БД, андеррайтер, зөвлөх	4	7	3
Ажилтнуудын тоо	538	593	55
Шинээр элссэн гишүүдийн тоо	30	4	(26)
Эрх нь цуцлагдсан гишүүдийн тоо	-	-	0



## ГИШҮҮН КОМПАНИУДЫН ЖАГСААЛТ

№	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Ажлын утас	ХАЯГ
1	Масдак ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	99881008 99221664	СБД-ийн 1-р хороо "Сарны титэм үзэсгэлэн" ХХК-ийн байр
2	Санар ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	462634	БЗД-ийн 13-р хороо Засаг даргын тамгын газрын дэргэд "Санар" ХХК-ны байр.
3	Зэргэд ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	367609	БГД 4-р хороо 5-р байр 24 тоот /Ханбүргэдэй/
4	Мэргэн санаа ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	451626	БЗД 15 хороолол 30 байр 4-р орц 67 тоот /Баянцээл худалдааны төвийн хажууд/
5	БиДиСек ХК	Андеррайтер, брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх	321763 / 313108 / 99010211	СБД, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1 байр, Empire building, Салбар 1: ЧД, 1-р хороо, Экспресс тауэр 3 давхарт
6	Өндөрхаан инвест ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	329292	УБ хот, Чингэлтэй дүүргийн ИХ тойруу 15-р гудамж "АЭРОГЕОДЕЗИ" ХК-ийн 3 давхар 301 тоот
7	Алтан хоромсог ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	450899	ХХААЯамны хойд талд Хоршоологчдын холбооны байранд 3 давхарт 317 тоот
8	Булган брокер ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	322708	СБД-ийн 3-р хороо 5-р хороолол, 9 дүгээр байрны 33 тоот
9	Дархан брокер ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	27831	Дархан-Уул аймаг Дархан сум 10 баг Залуучуудын өргөн чөлөө 380-1
10	Монсек ХХК	Брокер дилер Андерайтерийн үйл ажиллагаа	70153090	БЗД Энхтайвны өргөн чөлөө Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны байр 501 тоот
11	Тулгат чандмань баян ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа		Баянгол дүүргийн 2-р хороо Сөүлийн гудамж, УБТЗ-ын Төв эмнэлгийн захиргааны 208 тоот
12	Бумбат-Алтай ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	22166 / 99136219 / 98999993	СБД, Төв номын сангийн эсрэг талд, Бизнес Плаза төвийн 501 тоот
13	Азиа Пасифик секьюритис ХХК	Брокер дилер Андерайтерийн үйл ажиллагаа	77300660	СБД 1-р хороо Олимпийн гудамжийн 16/1 дүгээр байр 2 давхар
14	Таван богд ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	99089224	СБД, Сүхбаатарын талбай-2 Монголын үйлдвэрчдийн эвлэлийн байр 202 тоот, Баян-Өлгий аймаг Өлгий сум төв талбай 5 баг 24 байр 3 тоот
15	Аргай бэст ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	327026	ЧД-ийн 1-р хороо II - 40 мянгатын 1 байр 33 тоот
16	Дэлгэрхангай секьюритис ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	55252453	БГД 5-р хороо 10-р хороолол Энхтайвны гудамж-89 (DH-зочид буудалын 205 тоот)
17	Ники ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа		СБД, 1-р хороо, Жамьян гүний гудамж, ВСI компанийн байр, 302 тоот
18	Гендекс ХХК	Брокер дилер үйл ажиллагаа	7722 4777 / 77336777	СБД, 5-р хороо, 5-р хороолол, "Монгол даатгал-1" байрны 401 тоот
19	Монет ХХК	Брокер дилер Андерайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	324879 / 321899	СБД Амарын гудамж Үнэн сонины байранд 4-р давхарт
20	Ханш инвест ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	322241	СБД, 1-р 40 мянгат, 4-р хороо 53-р байр 1-орц 1 тоот /Орос элчингийн баруун талд /
21	Монгол секьюритис ХК	Брокер дилер үйл ажиллагаа	70120708	БЗД, 8 хороо "22-р бааз" ХК-ийн байр
22	АСЕ энд Т Капитал ХХК	Брокер дилер Андерайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	70101044	СБД, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө 11/1, /Баянгол зочид буудлын ард "Болор" төв 303, 305 тоот
23	Батс ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	326042 / 321013	СБД 1-р хороо 23-р байр 76 тоот
24	Глобал ассет ХХК	Брокер дилер хөрөнгө оруулалтын зөвлөх	320889	ЧД, 4-р хороо, 8/5 байр, Peace tower, 106 тоот
25	Нэйшнл секьюритис ХХК	Брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андерайтер	331754/ 01532-23088	СБД, 3-р хороо, Усны гудамж, Улсын циркийн урд талд, Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банкны төв байр, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Хүүхэд залуучуудын соёлын төвийн 1-р давхарт
26	Фронтнер ХХК	Броке дилер андерайтерийн үйл ажиллагаа	70119999 / 70111991	СБД, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, Blue Sky-705
27	Блүмсбюри секьюритис ХХК	Броке дилер андерайтерийн үйл ажиллагаа	77118188	СБД, 8-р хороо, Бага тойруу, Блюмон тауэр, 801 тоот
28	Ди си эф ХХК	Броке дилерийн үйл ажиллагаа	312604	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, хүнсний нэгийн ард 12-14 тоот
29	МИСС ХХК	Броке дилер андерайтерийн үйл ажиллагаа	70112023	СБД, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Central tower-902
30	Тэнгэр капитал ХХК	Брокер дилер, андерайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	70110637	Сүхбаатар дүүргийн 1-р хороо Сөүлийн гудамж-6/2 "Од плаза төв" 404 тоот
31	Санхүүгийн хөгжил инвест ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	70111335	БГД, 13-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө-13, "Жүр үр" ХХК-ийн 501 тоот
32	Эф си икс ХХК	Брокер дилер Андерайтерийн үйл ажиллагаа	70100323	БГД, 19-р хороо, "Монгол дизель" ХК-ийн байр /хуучнаар "Ану" мебель/, Дорноговь аймаг: Монгол ардын намын байрны 2-р давхарт, Говьсүмбэр аймаг: Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн байр, 201 тоот, Говь-Алтай аймаг: Монголбанкны байр-305
33	ТТСЕК ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	50055225	ЧД, Улаанбаатар 44, Их Тойруу-15, Аэрогеодези ХК-н байр, 210 тоот
34	Зюс капитал	Брокер дилер хөрөнгө оруулалтын зөвлөх	11-331436 / 11-329857	СБД 2-р хороо 220-н мянгат, Болор бизнес төв, 203 тоот
35	Ард капитал групп ХХК	Брокер дилер Андерайтерийн үйл ажиллагаа	11-310262	ЧД 1-р хороо Жүүлчин-35 Дельта төв 503 тоот
36	Эм ай би жи ХХК	Брокер дилер Андерайтерийн үйл ажиллагаа	11-362620 / 70110781	УБ хот, БГД, 16-р хороо, Амарсанаагийн гудамж, 12-1, Колорадо Бизнес төвийн 307 тоот
37	Гаули ХХК	Брокер дилер Андерайтерийн үйл ажиллагаа	70153300 / 99045961	УБ хот БЗД 1-р хороо Залуучуудын өргөн чөлөө "Сөүл бизнес" төвийн оффисын 4-р давхрын 401 тоот
38	Лайфтайм инвестмент ХХК	Брокер дилер Андерайтерийн үйл ажиллагаа	70121418	СБД, 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Хөх Сүлд группийн байр, 3 давхарт
39	Евразикапитал ХХК	Брокер дилер Андерайтерийн үйл ажиллагаа	70130078	УБ, СБД 1-р хороо, Олимпийн гудамж-16, Реженс 3-н давхар, 314 тоот
40	Финанс линк ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	77117008	СБД 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-14210, Хасбуу плаза 301.

## ГИШҮҮН КОМПАНИУДЫН ЖАГСААЛТ

№ Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Ажлын утас	ХАЯГ
41 Гүүдсек ХХК	Брокер дилер хөрөнгө оруулалтын зөвлөх	11-331878	СБД, Жамъян гүний гудамж-3, "Баттрейд Си" ХХК-ийн байрны 1 давхар
42 Монхан трейд ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	70160000 / 452489 / 976-11-458575	БЗД, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Монголын Хөдөө Аж Ахуй Хоршоологчдын Үндэсний Холбооны байрны 216, 404, 508 тоот
43 Лондон азиа капитал монголиа ХХК	Брокер дилер Андеррайтерийн үйл ажиллагаа	11-312307 / 311530	Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамжны Бодь Цамхагийн 403 тоот
44 Тэнгри секуритиес ХХК	Брокер, Дилерийн үйл ажиллагаа	70130695 / 70130696	БЗД 1-р хороо Залуучуудын гудамж 28 Сөүл бизнес центр 6-р давхар
45 Превалент ХХК	Брокер, Дилерийн үйл ажиллагаа	11-312677 / 99037926	СБД, 6-р хороо, Бага тойруу, Залуучуудын өргөн чөлөө 2Б-д байрлах "ЭКС төв"-ийн 1-р давхар
46 Эм Даблю Ти Эс ХХК	Брокер, Дилерийн үйл ажиллагаа	70116030	Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-2, 6-р хороо, 1/20 тоот
47 Рескап секюритииз ХХК	Брокер дилер, Андеррайтерийн үйл ажиллагаа	7010 0095	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 10/5 DHL төв байр, 2-р давхар
48 Ти Ди Би Капитал ХХК	Брокер, Андеррайтерийн үйл ажиллагаа	311914 / 70100261	ЧД, Жүүлчны гудамж, Бага тойруу 12, Худалдаа хөгжлийн банкны төв байр
49 Эс Жи Капитал ХХК	Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх	70119568	БЗД, 12-р хороо, Дүнжингарав, 107-р байр, 71 тоот
50 Юу Би Би Ди ХХК	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх	70116677	ЧД, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, "Экспресс таур"-ын 406 тоот
51 Юу Жи Эс ХХК	Брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх	320922 / 95092209	ЧД, 1-р хороо, 1-р 40 мянгат, 8-1 тоот /Ард кино театрын урд/
52 Новел инвестмент ХХК	Брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	317786	СБД, 3-р хороо, Нарны зам, Саруул төв, 108 тоот
53 Ай трейд ХХК	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх	99110292	СБД, Амбассадор резиденс оффис, 301 тоот
54 Капитал маркет корпораци ХХК	Брокер дилер, Андеррайтерийн үйл ажиллагаа	330896	ЧД, Төмөрчний гудамж, Капитал банкны төв байрны баруун талд
55 Тавантолгой хишиг ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	321326	СБД, Central tower, 1213 тоот
56 Догсон ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	98010818	СБД, 6-р хороо, Их сургуулийн гудамж 10-6, 1 давхарын үйлчилгээний танхим
57 Стандарт инвестмент ХХК	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх	70154444	БГД, 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, "Од Хийморь" 93/1
58 Гранддевелопмент ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	70140988	БГД, Энх тайвны өргөн чөлөө-92, ФБ платинум 4 давхар 403 тоот
59 Туушин инвест ХХК	Брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх Андеррайтерийн үйл ажиллагаа	325909	СБД, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, "Туушин" ХХК -ийн байр -211 тоот
60 Блэкстоун интернэйшнл ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа		ЧД, 6-р хороо, 6-р хороолол, 60/3 - 65 тоот
61 АБЖЯ ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	321823	ЧД, 4-р хороо Бага тойруу, 13-33 тоот
62 Соёмбо инвестмент корпораци ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	70112001 / 70112002	СБД, 1-р хороо, МҮЭХ-ны байр, 208 тоот
63 Гацурт трейд ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	70113377	СБД, 1-р хороо, 5-р хороолол, Чингисийн өргөн чөлөө, Алтай констракшин, 8давхарт
64 Очир-эрдэнэ инвест ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	313001	СБД, Тээвэрчдийн гудамж, Нью Майнд ХХК-ийн байр, 204 тоот
65 Би Би Эс ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	329713	СБД, 4-р хороо, 18 байр, 12 тоот
66 Бага хээр ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	70562017	Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг, Монголбанкны байр. 2-р давхарт
67 Зэт Жи Би ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	88116031	ЧД, 4-р хороо, Сүхбаатарын гудамж 2 тоот
68 Грийт секюритииз ХХК	Брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх	70119809	СБД, 10-р хороо, Их тойруу 22, Хаан хотел, 301 тоот
69 Грандлайн ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	88002006	БЗД, 1-р хороо, Токиогийн гудамж-2, "Серж эксклюзив хаус", 4-р давхарт
70 Тень Ди Сек ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	99545599	СХД, 18-р хороо, 21-р хороолол, 68 тоот байр
71 Баянзүрх инвест ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа		СБД, 7-р хороо, Эрхүүгийн гудамж-31, "Ориент төв" 402 тоот
72 Мөнх огторгуй ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	453563	БЗД, 5-р хороо, 15-р хороолол, ЭТӨЧ, 5-1 тоот
73 Скайхан ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	321737	ЧД, 1-р хороо, Экспресс тауэр, 302, 303 тоот
74 Зууны гарц секюритииз ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	70115152	ЧД, 1-р хороо, 1-р 40 мянгат, 8-2 тоот
75 Юнайтед секюритииз ХХК	Брокер дилер, андеррайтерийн үйл ажиллагаа	319041 /205/	ЧД, 1-р хороо, УБ хотын банкны байр, 403 тоот
76 Эм Жэй Ай Эйч ХХК	Брокер дилер, Андеррайтерийн үйл ажиллагаа	305167	БГД, 1-р хороо, 2-р хороолол, "Газар бизнес" төв
77 Голомт секюритииз ХХК	Брокерийн үйл ажиллагаа	70117676	ЧД, 1-р хороо, М100-р байр
78 Сикап ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	96056352	СХД, 18-р хороо, "Интер" ХХК-ийн байр, 9 давхар
79 Прогресс партнерс	Брокер дилерийн үйл ажиллагаа	99119374	БГД, 4-р хороо, 2-р хороолол, 8-02 тоот буюу Тээврийн товчооны баруун талд
80 Түшиг траст ХХК	Брокер дилерийн үйл ажиллагаа	99049916	ЧД, 2-р хороо, Их найман шарга төвийн 5н давхар

# “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН 2012 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2012.12.31

/мянган төгрөгөөр/

<b>Хөрөнгө</b>	
Бэлэн мөнгө	761,501.79
Дансны авлага	242,317.92
Бараа материал	83,205.60
Бусад эргэлтийн хөрөнгө	460,381.87
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,547,407.17
Эргэлтийн бус хөрөнгө	13,199,567.55
Нийт хуримтлагдсан элэгдэл	(872,436.08)
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,327,131.47
Хөрөнгийн нийт дүн	13,874,538.64
<b>Өр төлбөр</b>	
Дансны өглөг	2,100,382.67
Хувьцааны өглөг	
Ногдол ашгийн өглөг	
Өрийн бичгийн өглөг	
Бусад өглөг	
Өр төлбөрийн дүн	5,162,755.00
Өр төлбөрийн нийт дүн	5,162,755.00
<b>Эзэмшигчдийн өмч</b>	
Өмч	1,867,708.80
Хуримтлагдсан ашиг	(645,843.62)
тайлангийн үеийн	(227,194.24)
өмнөх үеийн	(418,649.38)
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	7,477,556.24
Эзэмшигчдийн өмчийн дүн	8,711,783.64
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн нийт дүн	13,874,538.64

# “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН 2012 ОНЫ ОРЛОГЫН ТАЙЛАН

2012.12.31

/мянган төгрөгөөр/

Орлого	
Үнэт цаасны арилжааны шимтгэл	779,232.20
Бүртгэлийн хураамжийн орлого	261,940.20
Бусад	450,408.50
Нийт орлого	1,491,580.90
Зардал	
Цалин, нийгмийн даатгалын шимтгэл	613,479.74
Ашиглалтын зардал	17,352.37
Албан томилолтын зардал, ТУЗ, удирдлагын зардал	72,733.01
Унаа, шатахуун, засварын зардал	80,136.63
Түүхий эд материалын зардал	25,933.58
Элэгдлийн зардал	247,140.85
Зар сурталчилгаа, сургалтын зардал	32,386.31
Шүүдан холбооны зардал	35,883.09
Бусал зардал	270,048.81
Нийт зардал	1,395,094.37
Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал	96,846.51
Үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг, алдагдал	(33,831.10)
Вальютын ханшийн өөрчлөлтийн ашиг, алдагдал	(253,380.15)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал	(287,211.25)
Татвар төлөхийн өмнөх ашиг	(190,724.75)
Орлогын татварын зардал	36,469.50
Тайлант үеийн цэвэр ашиг	(227,194.24)





Монголын хөрөнгийн бирж  
Хаяг: Сүхбаатарын талбай-2  
Улаанбаатар, Монгол  
Факс: (+976)-11-325170  
Утас: (+976)-11-313747  
Цахим хуудас: [www.mse.mn](http://www.mse.mn)  
И-майл: [info@mse.mn](mailto:info@mse.mn)